



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/235/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: "Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит" ХХК Утас: 99168735 Цахим хаяг: <a href="mailto:aetb.audit@gmail.com">aetb.audit@gmail.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.ЗОЛБАЯР ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/235/НА-СТА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 26,260.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

БШУС-ын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар тус сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр сургалтын менежер Ө.Золбаярыг томилсон байна.

Ингэснээр тус сургуулийн үйл ажиллагааг 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хойш захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэж удирдан, чиглүүлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.7 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	149,876,605.84	259,274,370.60
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	22,947,616.84	114,563,559.96
31200	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	22,947,616.84	114,563,559.96
31210	Төгрөг	22,947,616.84	114,563,559.96
31211	Төрийн сангийн харилцах	22,947,616.84	114,563,559.96
33	<b>АВЛАГА</b>	5,740,910.00	0
33500	<b>Бусад авлага</b>	5,740,910.00	0
33510	Байгууллагаас авах авлага	5,740,910.00	0
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	121,188,079.00	144,710,810.64
35100	<b>Түүхий эд материал</b>	51,750.00	131,750.00
35110	Тусгай зориулалттай материал	51,750.00	51,750.00
35130	Эм боох материал	0	80,000.00
35400	<b>Хангамжийн материал</b>	121,136,329.00	144,579,060.64
35410	Бичиг хэргийн материал	1,787,870.00	792,500.00
35420	Аж ахуйн материал	655,000.00	6,753,450.00
35440	Түлш, шатах тослох материал	700,000.00	0
35460	Хүнсний материал	2,059,545.00	3,988,330.00
35470	Бусад хангамжийн материал	115,933,914.00	133,044,780.64
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,569,910,603.08	1,340,537,971.06
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,569,910,603.08	1,340,537,971.06
39200	<b>Биет хөрөнгө</b>	1,380,956,731.28	1,159,179,971.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,118,878,974.00	1,118,878,974.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-181,157,413.42	-339,217,832.28
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	650,403,641.28	725,761,581.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-375,024,382.35	-517,584,458.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	165,025,571.03	189,491,571.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-92,409,189.72	-109,988,915.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	84,414,531.48	84,414,531.48
39215	Хуримтлагдсан элэгдэл	-34,109,669.62	-43,394,270.48
39217	Ном	44,934,668.60	50,818,789.60
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	188,953,871.80	181,358,000.00
39301	Програм хангамж	44,023,050.00	45,343,050.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-30,809,178.20	-39,725,050.00
39303	Бусад биет бус хөрөнгө	175,740,000.00	175,740,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	1,719,787,208.92	1,599,812,341.66
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	1,576,497.75	1,292,163.59
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,576,497.75	1,292,163.59
41300	<b>Өглөг</b>	1,576,497.75	1,292,163.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,078,424.75	986,593.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	300,073.00	300,073.00
41360	<b>Бусад өглөг</b>	198,000.00	5,497.39
41361	Байгууллагад төлөх өглөг	198,000.00	5,497.39
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,718,210,711.17	1,598,520,178.07
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,718,210,711.17	1,598,520,178.07
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,128,928,525.00	1,128,928,525.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,128,928,525.00	1,128,928,525.00
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-525,445,005.26	-645,135,538.36
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,239,872,601.16	-525,445,005.26
51220	Тайлант үеийн үр дүн	1,714,427,595.90	-119,690,533.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,114,727,191.43	1,114,727,191.43

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,719,787,208.92	1,599,812,341.66
---	--	------------------	------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,787,299,084.97	2,420,656,683.31
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,869,664,459.05</b>	<b>128,466,365.64</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,869,664,459.05	128,466,365.64
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>46,867,793.82</b>	<b>65,083,138.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,781,665.00	30,730,248.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,086,128.82	34,352,890.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,706,628,621.23	48,025,061.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	116,168,044.00	15,358,166.64
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,917,634,625.92</b>	<b>2,292,190,317.67</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,713,317,000.00</b>	<b>2,141,522,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,713,317,000.00	2,141,522,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,397,975.18</b>	<b>0</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,397,975.18	0
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>194,919,650.74</b>	<b>150,668,217.67</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	194,919,650.74	150,668,217.67
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,072,871,489.07	2,540,347,216.41
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,072,871,489.07</b>	<b>2,540,347,216.41</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,951,129,454.07</b>	<b>2,408,363,523.91</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,310,229,648.00</b>	<b>1,598,223,906.80</b>
210101	Үндсэн цалин	812,116,402.11	1,598,223,906.80
210102	Нэмэгдэл	435,976,905.48	0
210104	Урамшуулал	62,136,340.41	0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>163,206,229.52</b>	<b>192,524,241.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	112,076,252.14	132,138,247.68
210202	Тэтгэмжийн даатгал	13,185,720.05	15,527,086.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,518,336.13	12,408,268.55
210204	Ажилгүйдлийн даатгал	2,482,828.49	2,924,190.88
210205	Эрүүл мэндийн даатгал	24,943,092.71	29,526,447.47
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>133,457,499.00</b>	<b>136,093,217.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,706,920.00	16,588,256.67
210302	Түлш, халаалт	103,100,317.00	101,290,197.00
210303	Цэвэр, бохир ус	14,650,262.00	18,214,764.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,998,190.00</b>	<b>0</b>
210401	Бичиг хэрэг	5,353,230.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,644,960.00	0
2105	<b>Нормативд зардал</b>	<b>24,950,846.00</b>	<b>38,124,307.16</b>
210502	Хоол, хүнс	24,950,846.00	38,124,307.16
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,510,150.00</b>	<b>0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500.00	0
210604	Урсгал засвар	15,507,650.00	0

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,751,000.00</b>	<b>18,651,608.19</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,071,000.00	8,300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,680,000.00	10,351,608.19
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>259,025,891.55</b>	<b>424,746,243.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,337,083.40	64,440,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,399,290.00	23,904,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	225,289,518.15	336,400,693.02
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>121,742,035.00</b>	<b>131,983,692.50</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>121,742,035.00</b>	<b>131,983,692.50</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	104,967,235.00	114,914,492.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,774,800.00	17,069,200.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,714,427,595.90</b>	<b>-119,690,533.10</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,714,427,595.90</b>	<b>-119,690,533.10</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,964,502,419.74</b>	<b>2,357,273,455.67</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,867,793.82</b>	<b>65,083,138.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	46,867,793.82	65,083,138.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>46,867,793.82</b>	<b>65,083,138.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,781,665.00	30,730,248.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,086,128.82	34,352,890.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,917,634,625.92</b>	<b>2,292,190,317.67</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,713,317,000.00</b>	<b>2,141,522,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,713,317,000.00	2,141,522,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,397,975.18</b>	<b>0</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,397,975.18	0
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>194,919,650.74</b>	<b>150,668,217.67</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	194,919,650.74	150,668,217.67
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,852,983,302.90</b>	<b>2,206,654,512.55</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,852,983,302.90</b>	<b>2,206,654,512.55</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,728,430,979.90</b>	<b>2,070,682,484.89</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,310,229,671.42</b>	<b>1,598,508,240.96</b>
210101	Үндсэн цалин	818,068,316.73	967,518,739.22
210102	Нэмэгдэл	433,522,563.85	571,029,189.20
210104	Урамшуулал	58,638,790.84	59,960,312.54
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>163,206,206.08</b>	<b>192,524,241.07</b>
210201	Тэтгэврийн даатгал	112,071,490.26	132,138,247.68
210202	Тэтгэмжийн даатгал	13,186,904.66	15,527,086.49

210203	ҮОМШӨ-ний даатгал	10,519,283.82	12,408,268.55
210204	Ажилгүйдлийн даатгал	2,483,065.41	2,924,190.88
210205	Эрүүл мэндийн даатгал	24,945,461.93	29,526,447.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>133,457,500.00</b>	<b>136,093,217.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,706,921.00	16,588,256.67
210302	Түлш, халаалт	103,100,317.00	101,290,197.00
210303	Цэвэр, бохир ус	14,650,262.00	18,214,764.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,696,350.00</b>	<b>0</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,696,350.00	0
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>23,434,559.00</b>	<b>8,364,797.00</b>
210502	Хоол, хүнс	23,241,059.00	8,364,797.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	193,500.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,062,500.00</b>	<b>14,575,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500.00	0
210604	Урсгал засвар	20,060,000.00	14,575,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,751,000.00</b>	<b>18,778,478.19</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,071,000.00	8,101,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,680,000.00	10,677,478.19
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>59,593,193.40</b>	<b>101,838,510.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,287,593.40	81,993,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,305,600.00	19,845,340.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>124,552,323.00</b>	<b>135,972,027.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>124,552,323.00</b>	<b>135,972,027.66</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	107,777,523.00	118,902,827.66
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,774,800.00	17,069,200.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>111,519,116.84</b>	<b>150,618,943.12</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>88,571,500.00</b>	<b>59,003,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>88,571,500.00</b>	<b>59,003,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>88,571,500.00</b>	<b>59,003,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	88,571,500.00	59,003,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-88,571,500.00</b>	<b>-59,003,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>22,947,616.84</b>	<b>91,615,943.12</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	22,947,616.84
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,947,616.84	114,563,559.96

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,128,928,525.00	1,114,727,191.43	-525,445,005.26	1,718,210,711.17

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,128,928,525.00</b>	<b>1,114,727,191.43</b>	<b>-525,445,005.26</b>	<b>1,718,210,711.17</b>
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-119,690,533.10	-119,690,533.10
10	<b>2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>1,128,928,525.00</b>	<b>1,114,727,191.43</b>	<b>-645,135,538.36</b>	<b>1,598,520,178.07</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,395,135,917.67</b>	<b>2,265,657,512.55</b>	<b>129,478,405.12</b>	<b>94.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,395,135,917.67</b>	<b>2,265,657,512.55</b>	<b>129,478,405.12</b>	<b>94.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,242,153,517.67</b>	<b>2,129,685,484.89</b>	<b>112,468,032.78</b>	<b>95.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,675,839,000.00</b>	<b>1,598,508,240.96</b>	<b>77,330,759.04</b>	<b>95.4</b>
210101	Үндсэн цалин	1,134,079,200.00	967,518,739.22	166,560,460.78	<b>85.3</b>
210102	Нэмэгдэл	472,777,700.00	571,029,189.20	(98,251,489.20)	<b>120.8</b>
210104	Урамшуулал	68,982,100.00	59,960,312.54	9,021,787.46	<b>86.9</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>209,479,400.00</b>	<b>192,524,241.07</b>	<b>16,955,158.93</b>	<b>91.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	142,445,800.00	132,138,247.68	10,307,552.32	<b>92.8</b>
210202	Тэтгэмжийн даатгал	16,758,400.00	15,527,086.49	1,231,313.51	<b>92.7</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,406,700.00	12,408,268.55	998,431.45	<b>92.6</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	3,351,700.00	2,924,190.88	427,509.12	<b>87.2</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	33,516,800.00	29,526,447.47	3,990,352.53	<b>88.1</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>136,093,217.67</b>	<b>136,093,217.67</b>	-	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,588,256.67	16,588,256.67	-	<b>100.0</b>
210302	Түлш, халаалт	101,290,197.00	101,290,197.00	-	<b>100.0</b>
210303	Цэвэр, бохир ус	18,214,764.00	18,214,764.00	-	<b>100.0</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,365,500.00</b>	<b>8,364,797.00</b>	<b>703.00</b>	<b>100.0</b>
210502	Хоол, хүнс	8,365,500.00	8,364,797.00	703.00	<b>100.0</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,575,000.00</b>	<b>14,575,000.00</b>	-	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	14,575,000.00	14,575,000.00	-	<b>100.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,231,200.00</b>	<b>20,098,478.19</b>	<b>1,132,721.81</b>	<b>94.7</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,101,000.00	8,101,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,130,200.00	11,997,478.19	1,132,721.81	91.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>176,570,200.00</b>	<b>159,521,510.00</b>	<b>17,048,690.00</b>	<b>90.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,724,200.00	139,676,170.00	17,048,030.00	89.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,846,000.00	19,845,340.00	660.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>152,982,400.00</b>	<b>135,972,027.66</b>	<b>17,010,372.34</b>	<b>88.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>152,982,400.00</b>	<b>135,972,027.66</b>	<b>17,010,372.34</b>	<b>88.9</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	135,913,200.00	118,902,827.66	17,010,372.34	87.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,069,200.00	17,069,200.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,395,135,917.67</b>	<b>2,357,273,455.67</b>	<b>37,862,462.00</b>	<b>98.4</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,141,522,100.00</b>	<b>2,141,522,100.00</b>	-	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,141,522,100.00	2,141,522,100.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>150,668,217.67</b>	<b>150,668,217.67</b>	-	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	150,668,217.67	150,668,217.67	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>102,945,600.00</b>	<b>65,083,138.00</b>	<b>37,862,462.00</b>	<b>63.2</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,757,500.00	30,730,248.00	14,027,252.00	68.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,240,500.00	34,352,890.00	887,610.00	97.5
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22,947,600.00		22,947,600.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		22,947,616.84	(22,947,616.84)	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		114,563,559.96	(114,563,559.96)	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>			-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>74</b>	<b>74</b>	-	
620001	Удирдах ажилтан	3	3	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	56	56	-	
620003	Үйлчлэх ажилтан	15	15	-	
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>580</b>	<b>1115</b>	-	
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>580</b>	<b>1115</b>	-	
630001	Төрийн өмчит ЕБС	580	1115	-	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь “Сургалтын таатай орчин бүрдүүлж, багшийн хөгжлийг хангах замаар суралцагчдад чанартай боловсрол эзэмшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн эрх зүйн орчныг шинэчлэх,
- Сургалтын таатай орчин бүрдүүлж хүртээмжийг нэмэгдүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 06, 5 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон.*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:  
1. "ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",  
2. "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119,974.9 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,947.6	114,563.6	91,615.9
Авлага	5,740.9	0.0	(5,740.9)
Бараа материал	121,188.1	144,710.8	23,522.7
Үндсэн хөрөнгө	1,569,910.6	1,340,538.0	(229,372.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,719,787.2</b>	<b>1,599,812.3</b>	<b>(119,974.9)</b>
Өр төлбөр	1,576.5	1,292.2	(284.3)

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,718,210.7	1,598,520.2	(119,690.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,719,787.2	1,599,812.3	(119,974.9)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 114,563.6 мянган төгрөг болж 91,615.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 144,710.8 мянган төгрөг болж 23,522.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 223,368.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн БШУГ-аас 6,903.2 мянган төгрөгийн сурах бичиг, газрын зураг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,871.7 мянган төгрөгийн ширээний теннисний хэрэгсэл, Байгаль орчны менежментийн системийн төвөөс 6,583.2 мянган төгрөгийн эко танхимын хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 215,203.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,340,538.0 мянган төгрөг болж 229,372.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 59,003.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, программ хангамжийг худалдан авч, БШУЯ-наас 17,640.9 мянган төгрөгийн физик хими, технологийн хичээлийн тоног төхөөрөмж, Сүхбаатар сумын хөрөнгө оруулалтаар 19,900.0 мянган төгрөгийн камер, аймгийн БШУГ-аас 5,884.1 мянган төгрөгийн ном, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 4,600.0 мянган төгрөгийн теннисний ширээг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 336,400.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,592,200.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 166,247.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,781,415.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 549,322.7 мянган төгрөгөөр нэмж 2,141,522.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 15,579.5 бууруулж 150,668.2 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 79,998.0 мянган төгрөг урьд оны

үлдэгдлээс 22,947.6 мянган төгрөг нийт 2,395,135.9 мянган төгрөгөөр төсвийг эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого дутуу төвлөрснөөс нийт 2,380,221.0 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрүүлж урсгал үйл ажиллагаанд 2,265,657.5 мянган төгрөгийг зарцуулж, 114,563.5 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,265,657.5 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 69,435.7 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааны зардлыг 21,758.1 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 17,010.4 мянган төгрөгөөр, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын зардлыг 16,018.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

		/мянган төгрөгөөр/			
Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-байр ашиглалтын үйлчилгээ	5,252.1	5,235.8	16.3	99.7
2	80312-сургалт семинар	4,436.7	2,520.1	1,916.6	56.8
3	81605 - Эрүүл мэндийг дэмжих	7,212.8	6,610.0	602.8	91.6
4	<b>81801-үдийн цай</b>	<b>135,913.2</b>	<b>118,902.8</b>	<b>17,010.4</b>	<b>87.5</b>
5	81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	56,665.0	55,946.4	718.6	98.7
6	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	11,817.2	9,816.0	2,001.2	83.1
7	<b>81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх</b>	<b>1,680,674.2</b>	<b>1,611,238.5</b>	<b>69,435.7</b>	<b>95.9</b>
8	<b>81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа</b>	<b>261,041.0</b>	<b>239,282.8</b>	<b>21,758.2</b>	<b>91.6</b>
9	<b>81844-гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт</b>	<b>73,203.8</b>	<b>57,185.4</b>	<b>16,018.4</b>	<b>78.1</b>
10	81848-сурах бичгийн түрээс	8,101.0	8,101.0	-	100.0
11	83603-дээд шатны төсвөөс хуваарилсан	150.7	150.5	0.2	99.9
<b>Дүн</b>		<b>2,244,467.7</b>	<b>2,114,989.3</b>	<b>129,478.4</b>	<b>94.2</b>
12	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	150,668.2	150,668.2	0.0	100.0
<b>Нийт</b>		<b>2,395,135.9</b>	<b>2,265,613.2</b>	<b>129,478.4</b>	<b>94.6</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Халиун уул” ХХК, Алтан есүй ХХК, Алтан тариа ХХК, Цахим ертөнц ХХК, иргэн Ц.Цэсэм, Л.Өлзийсайхан, Н.Бүджаргал шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит” ХХК-ийн аудитор О.Чулуунбаатар, Ю.Уртнасан, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,072,871.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 20,728.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 166 мэдээллийг байршуулахаас 5 төрлийн мэдээг хоцроосон байна. Үүнд: Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Төсөв, гүйцэтгэлийн батлагдсан төсвийн мэдээ,
- Төсөв гүйцэтгэлийн-төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар,
- Дараа жилийн төсвийн төсөл,
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага,

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 54,024.7 мянган төгрөгийн 5 гүйлгээ, орлогын мөнгөн гүйлгээний 2,303,597.0 мянган төгрөгийн 29 мэдээллийг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 135,913.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Халиун уул” ХХК, Алтан есүй ХХК, Алтан тариа ХХК, Цахим ертөнц ХХК, иргэн Ц.Цэсэм, Л.Өлзийсайхан, Н.Бүджаргал нартай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй, мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн зөрчлийг арилгаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах гэсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	9,626.1	1	8,644.6	89.8
Зөвлөмж	1	1,052.7	1	1,052.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>10,678.8</b>	<b>2</b>	<b>9,697.3</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,292.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөвлөмж өгөгдлөө.

### 5.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ, ХХОАТ-ын 992.1 мянган төгрөгийн, хүнсний материалын 300.1 мянган төгрөгийн зэрэг нийт 1,292.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	1,292.2					1	1,292.2				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,292.2</b>					<b>1</b>	<b>1,292.2</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1					
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>	<b>1</b>				<b>1</b>					